



МОНГОЛ УЛСЫН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН  
ТУШААЛ

2021 оны 03 сарын 02 өдөр

Дугаар А/26


Улаанбаатар хот

Коронавируст халдвар (КОВИД-19)-ын  
цар тахлын үед сүрьеэгийн тусламж үйлчилгээний  
тасралтгүй байдлыг хангах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1, Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.23 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын үед сүрьеэгийн тусламж үйлчилгээний тасралтгүй байдлыг хангах зарчмыг нэгдүгээр, Коронавируст халдвар /КОВИД-19/-ын цар тахлын үед сүрьеэгийн тусламж үйлчилгээний тасралтгүй байдлыг хангах үйл ажиллагааны төлөвлөгөөг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлын үед сүрьеэгийн тусламж үйлчилгээний тасралтгүй байдлыг хангах зарчмыг баримтлан, тусламж үйлчилгээг тасралтгүй хүргэх явцыг удирдлага, зохион байгуулалтаар хангахыг Эмнэлгийн тусламж үйлчилгээний газар /Ж.Нарангэрэл/, Нийтийн эрүүл мэндийн газар /Д.Баярболд/, мэргэжлийн арга зүй, мэдээллээр хангаж ажиллахыг Халдварт өвчин судлалын үндэсний төв /Ц.Билэгтсайхан/, орон нутгийн хэмжээнд зохион байгуулж, үр дүнг улирал бүр тайлагнахыг аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газар, Бүсийн оношилгоо эмчилгээний төв, Нэгдсэн эмнэлэг, эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нарт тус тус үүрэг болгосугай.
3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Нийтийн эрүүл мэндийн газар /Д.Баярболд/, Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /С.Төгсдэлгэр/-т тус тус үүрэг болгосугай.
4. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Эрүүл мэндийн сайдын 2021 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн 244 дүгээр тушаал, 2021 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн "КОВИД-19 цар тахлын нөхцөл байдалд тохируулан сүрьеэгийн тусламж үйлчилгээ үзүүлэх нэгдсэн төлөвлөгөө"-г тус тус хүчингүйд тооцсугай.

САЙД



С.ЭНХБОЛД

141220724



Эрүүл мэндийн сайдын 2020-08-03-ны сарын 03-ны өдрийн АМН дугаар тушаалын нэгдүгээр хавсралт

**КОРОНАВИРУСТ ХАЛДВАР (КОВИД-19)-ЫН ЦАР ТАХЛЫН ҮЕД СҮРЬЕЭГИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ТАСРАЛТГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ ЗАРЧИМ**

№	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	IV		
		I	II	III
		Ногоон түвшин (Тархалт бага тогтвортой)	Шар түвшин (Зөөвөрлөгдсөн/алаг цоог тархалттай)	Улбар шар түвшин (Халдвар голомтот тархалттай)
Нэг. Сүрьеэгийн илрүүлэг: идэвхтэй, идэвхгүй илрүүлэг, хамтарсан үзлэг /КОВИД-19/ шинжилгээ, хавьтлын тандалт судалгаа				
1	Амбулаторийн үзлэг (эрүүл мэндийн байгууллага)	Эрүүл мэндийн сайдын 2021 оны 30 дугаар тушаалын 7 дугаар хавсралтын дагуу гүйцэтгэнэ.	Эрүүл мэндийн сайдын 2021 оны 30 дугаар хавсралтын дагуу гүйцэтгэнэ; Халдвараас сэргийлэх хяналтын дэглэмийг үйлчлүүлэгчдэд мөрдүүлнэ: зай барих, амны хаалт зүүх, гар халдваргүйжүүлэх; КОВИД-19-ийн сэжигтэй тохиолдлыг мөрдөж байгаа Эрүүл мэндийн Сайдын тушаалын дагуу зохицуулна.	Улаан түвшин (Халдвар хүн амын дунд тархсан) Хөл хориогүй үед Хөл хориотой үед
2	Идэвхтэй илрүүлэг (эрүүл мэндийн байгууллага, төрийн бус байгууллага)	Эрүүл мэндийн сайдын 2021 оны 30 дугаар тушаалын 7 дугаар хавсралтын дагуу гүйцэтгэнэ; Эрсдэлт бүлгийн хүн амыг тодорхойлж, үзлэгт бүрэн хамруулна;	Эрүүл мэндийн сайдын 2021 оны 30 дугаар тушаалын 7 дугаар хавсралтын дагуу гүйцэтгэнэ; Халдвараас сэргийлэх хяналтын дэглэмийг үйлчлүүлэгчдэд мөрдүүлнэ: нэг дор олон хүн цуглуулахгүй, зай барих, амны хаалт зүүх, гар халдваргүйжүүлэх	Телемедицин: эмч-үйлчлүүлэгч, эмч нарын зөвлөгөөн; Утсаар зөвлөгөө өгнө;
		Гараг, цагийн зохицуулалт хийнэ (хяналт, урьдчилан сэргийлэх үзлэг, эрүүл зүйн үзлэг г.м.)		
		Эрсдэлт бүлгийн хүн амыг тодорхойлж, үзлэгт бүрэн хамруулна; Эрүүл мэндийн сайдын 2021 оны 30 дугаар тушаалын 7 дугаар хавсралтын дагуу гүйцэтгэнэ; Халдвараас сэргийлэх хяналтын дэглэмийг үйлчлүүлэгчдэд мөрдүүлнэ: нэг дор олон хүн цуглуулахгүй, зай барих, амны хаалт зүүх, гар халдваргүйжүүлэх		
		Зохيون байгуулахгүй		

3	Хавьтлын үзлэг шинжилгээ	Эрүүл мэндийн сайдын 2021 оны 30 дугаар тушаалын 7 дугаар хавсралтын 2.5-ын дагуу гүйцэтгэнэ.	Илрүүлэгт хамрагдаж байгаа иргэдийн 50-аас доошгүй хувьд КОВИД-19-ийн халдвар илрүүлэх түргэвчилсэн шинжилгээ хийнэ;	Илрүүлэгт хамрагдаж байгаа иргэдийн 30-аас доошгүй хувьд КОВИД-19-ийн халдвар илрүүлэх түргэвчилсэн шинжилгээ хийнэ;	<p>- Эрүүл мэндийн сайдын 2021 оны 30 дугаар тушаалын 7 дугаар хавсралтын дагуу гүйцэтгэнэ;</p> <p>- Халдвараас сэргийлэх хяналтын дэглэмийг үйлчлүүлэгчдэд мөрдүүлнэ; нэг дор олон хүн цуглуулахгүй, зай барих, амны хаалт зүүх, гар халдваргүйжүүлэх</p> <p>- Гараг, цагийн зохицуулалт хийнэ;</p> <p>- КОВИД-19-ийн сэжигтэй тохиолдлыг мөрдөж байгаа Эрүүл мэндийн сайдын тушаалын дагуу зохицуулалт хийнэ.</p>	<p>- Телемедицин: эмч-үйлчлүүлэгч, эмч нарын зөвлөгөөн;</p> <p>- Утсаар зөвлөгөө өгнө;</p> <p>- Асуумжаар сүрьеэ сэжиглэсэн тохиолдолд цэрний сорьцыг эрүүл мэндийн байгууллагаас очиж авна;</p> <p>- Асуумжаар КОВИД-19 сэжиглэсэн тохиолдолд сорьцыг эрүүл мэндийн байгууллагаас очиж авна.</p>
---	--------------------------	---	--	--	---	---



4	КОВИД-19 халдварын батлагдсан тохиолдлыг эмнэлэгт эмчлүүлэх сүрьеэгийн илрүүлэг хийх	<ul style="list-style-type: none"> <li>- КОВИД-19 халдварын батлагдсан тохиолдол бүрд дараах эмнэл зүйн шинжээр тандалт хийнэ. Үүнд: <ul style="list-style-type: none"> <li>• 2 долоо хоногоос удаан хугацаанд ханиалгах</li> <li>• 2 долоо хоногоос удаан хугацаанд халуурах</li> <li>• Биеийн жин огцом алдах</li> <li>• Шене хөлрөх</li> </ul> </li> <li>- Сүрьеэтэй өвчтөний хавьтал, өмнө сүрьеэгээр өвдөж байсан бол цээжний гэрлийн шинжилгээ хийнэ. Үүнд: <ul style="list-style-type: none"> <li>• КОВИД-19-ийн оношилгоо, эмчилгээний үед цээжний рентген, КТГ шинжилгээгээр сүрьеэ байж болзошгүй өөрчлөлт илэрсэн бол цэрний сорьц цуглуулж, Gene-Xpert шинжилгээнд хамруулна;</li> <li>• КОВИД-19 өвчний дараах хяналтын рентген, КТГ шинжилгээгээр сүрьеэ байж болзошгүй өөрчлөлт илэрсэн бол цэрний сорьц цуглуулж, Gene-Xpert шинжилгээнд хамруулна.</li> </ul> </li> </ul>
<b>Хоёр. Сүрьеэгийн оношлогоо, шинжилгээ: сорьц цуглуулах, хадгалах, тээвэрлэх, хариу илгээх</b>		
1	Цэрний сорьц цуглуулах (оношилгоо, эмчилгээний хяналт)	<ul style="list-style-type: none"> <li>- Эрүүл мэндийн сайдын 2021 оны 30 дугаар тушаалын 7 дугаар хавсралтын дагуу гүйцэтгэнэ;</li> <li>- Халдвараас сэргийлэх хяналтын дэглэмийг үйлчлүүлэгчдэд мөрдүүлнэ: нэг дор олон хүн цуглуулахгүй, зай барих, амны хаалт зүүх, гар халдваргүйжүүлэх;</li> <li>- Амбулаторийн үзлэг, сүрьеэгийн идэвхтэй илрүүлгийг зохион байгуулахдаа гараг, цагийн зохицуулалтыг баримтална.</li> </ul>
2	Сорьц хадгалах, тээвэрлэх	Эрүүл мэндийн сайд, Зам тээвэр хөгжлийн сайдын хамтарсан 2020 оны 413/165 дугаар тушаалын дагуу гүйцэтгэнэ.
3	Шинжилгээний хариуг мэдээлэх	Шинжилгээний хариуг эмч, үйлчлүүлэгчид цаасан болон цахим хэлбэрээр хүргэнэ.
<b>Гурав. Сүрьеэгийн эмчилгээний хяналт: хөл хорио, хязгаарлалтын дэглэм тогтоосон үед зайнаас хяналт тавих, тарилгатай эмчилгээний тасралтгүй байдлыг хангах</b>		

<p>1</p> <p>Өрх, сумын эрүүл мэндийн төвд хийх сүрьеэгийн эмчилгээ, эмчилгээний хяналт</p>	<ul style="list-style-type: none"> <li>- Эрүүл мэндийн сайдын 2021 оны 30 дугаар тушаалын 7 дугаар хавсралтын дагуу гүйцэтгэнэ;</li> <li>- Эмийг өдөр бүрийн хяналттай уулгана;</li> <li>- Хяналтын үзлэг, шинжилгээнд товллолт хугацаанд хамруулна;</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Өвчтөнд 7-14 хоногийн эмийг гэрт нь хүргэж, цахимаар хянаана.</li> <li>- Гэр бүлийн гишүүдийн хяналтад тулгуурлана;</li> <li>- Эмчилгээ, лабораторийн шинжилгээ хийлгэхдээ харьяалал харгалзахгүйгээр хамгийн ойр сүрьеэгийн диспансерт хандана.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Дараагийн товллолт үзлэгт орох хүртэлх эмийг гэрт нь хүргэж, цахимаар хянаана;</li> <li>- Гэр бүлийн гишүүдийн хяналтад тулгуурлана;</li> <li>- Эмчилгээ, лабораторийн шинжилгээ хийлгэхдээ харьяалал харгалзахгүйгээр хамгийн ойр сүрьеэгийн диспансерт хандана.</li> </ul>
<p>2</p> <p>Сүрьеэгийн диспансерт хийх эмчилгээ, эмчилгээний хяналт</p>	<ul style="list-style-type: none"> <li>- Эрүүл мэндийн сайдын 2021 оны 30 дугаар тушаалын 7 дугаар хавсралтын дагуу гүйцэтгэнэ;</li> <li>- Эмийг өдөр бүрийн хяналттай уулгана;</li> <li>- Хяналтын үзлэг, шинжилгээнд товллолт хугацаанд хамруулна;</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Өрх, сумын эмч, СДИ-ний хянаж байгаа өвчтөний 20-оос доошгүй хувьд давхар хяналт хийнэ;</li> <li>- Өвчтөнд 7-14 хоногийн эмийг өгч явуулна;</li> <li>- Цахим хяналт хийнэ;</li> <li>- Харьяалал харгалзахгүйгээр эмчилгээ, лабораторийн шинжилгээг хийнэ;</li> <li>- Эмчилгээ ба эмийн гаж нөлөөний хяналтыг цахимаар хийнэ;</li> <li>- Халдвараас сэргийлэх хяналтын дэглэмийг үйлчлүүлэгчдэд мөрдүүлнэ. нэг дор олон хүн цуглуулахгүй, зай барих, амны хаалт зүүх, гар халдваргүйжүүлэх.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Өрх, сумын эмч, СДИ-ний хянаж байгаа өвчтөний 20-оос доошгүй хувьд давхар хяналт хийнэ</li> <li>- Дараагийн товллолт үзлэгт орох хүртэлх эмийг хүргэнэ;</li> <li>- Цахим хяналт хийнэ;</li> <li>- Харьяалал харгалзахгүйгээр эмчилгээ, лабораторийн шинжилгээг хийнэ;</li> <li>- Эмчилгээ ба эмийн гаж нөлөөний хяналтыг цахимаар хийнэ.</li> </ul>



3	Эрүүл мэндийн сайн идэвхтэнээр хийх эмчилгээ, эмчилгээний хяналт	Эрүүл мэндийн сайдын 2021 оны 30 дугаар тушаалын 7 дугаар хавсралтын дагуу гүйцэтгэнэ.	<ul style="list-style-type: none"> <li>- Сүрьеэгийн диспансераас 28 хоногоор эмийг СДИ авна;</li> <li>- Өвчтөнд эмийг 7-14 хоногоор хүргэж, цахимаар хянаана;</li> <li>- Гэр бүлийн гишүүдийн хяналтанд тулгуурлана.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Сүрьеэгийн диспансериас 28 хоногоор эмийг СДИ авна;</li> <li>- Дараагийн товлोलт үзлэгт орох хүртэлх эмийг гэрт нь хүргэж, цахимаар хянаана;</li> <li>- Гэр бүлийн гишүүдийн хяналтанд тулгуурлана.</li> </ul>
4	Стационарт хийх эмчилгээ, эмчилгээний хяналт	Эрүүл мэндийн сайдын 2021 оны 30 дугаар тушаалын 7 дугаар хавсралтын дагуу гүйцэтгэнэ.	<ul style="list-style-type: none"> <li>- Эрэмбэлж зохицуулалт хийнэ;</li> <li>- Сүрьеэгийн үндсэн тусламж үйлчилгээнд орны 80 хувийг хэвээр байлгана.</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>- Эрэмбэлж зохицуулалт хийнэ;</li> <li>- Сүрьеэгийн үндсэн тусламж үйлчилгээнд орны 50 хувийг хэвээр байлгана.</li> </ul>
5	Явуулын тусламж үйлчилгээ	Эрүүл мэндийн сайдын 2021 оны 30 дугаар тушаалын 7 дугаар хавсралтын дагуу гүйцэтгэнэ.	Эмчилгээ таслах эрсдэлтэй, шаардлагатай өвчтөнийг эрэмбэлж, эрүүл мэндийн байгууллага очиж тусламж үйлчилгээ үзүүлнэ.	

Эрүүл мэндийн сайдын 2020 оны  
03 сарын 04-ны өдрийн АМБ дугаар  
тушаалын хоёрдугаар хавсралт

**КОРОНАВИРУСТ ХАЛДВАР (КОВИД-19)-ЫН ЦАР ТАХЛЫН ҮЕД СҮРЬЕЭГИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ  
ТАСРАЛТГҮЙ БАЙДЛЫГ ХАНГАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ**

д/д	Үйл ажиллагааны хүрээ	№	Хэрэгжүүлэх үйл ажиллагаа	Хугацаа	Хэрэгжүүлэгч байгууллага	Хамтран ажиллах байгууллага	Шалгуур үзүүлэлт
<b>Нэг. Сүрьеэгийн илрүүлэг: идэвхтэй, идэвхгүй илрүүлэг, хамтарсан үзлэг /КОВИД-19/ шинжилгээ, хавьтлын тандалт судалгаа, үйл ажиллагааны үнэлгээ</b>							
1.1	Идэвхгүй илрүүлэлт-эмнэлэгт хандах үед	1	Сүрьеэгийн түвшинд хүргэж гаргах, санхүүжилтийг зорилтот нэмэгдүүлэх шийдвэрлэх	Жилийн турш	Аймаг, нийслэлийн ЭМГ, БОЭТ, НЭ, ДЭМТ	Аймаг, нийслэлийн ЗДТГ, ХӨСҮТ-СТСА ТББ	Шинэ, дахилтат сүрьеэгийн тохиолдлын тоо
		2	Аймаг, дүүргийн сайн дурын дамжуулан зорилтот сүрьеэгийн илрүүлэг үзлэгт хамруулах	Жилийн турш	МСТН	Глобаль сан, аймаг, дүүргийн сүрьеэгийн диспансери	Илрүүлсэн тохиолдлын тоо, хувь
		3	Сайн дурын хамруулах	Хагас жилд	МСТН	ХӨСҮТ, СТСА	Цахим сургалтын тоо, оролцогчдын тоо
		4	Өрхийн 14 хоногоос өгүүлэмжтэй цуглуулах, сүрьеэгийн эмгэгтэй, дээш ханиалгасан иргэдээс цэрний сорьц илгээх	Жилийн турш	МӨАУМХ	Өрхийн эрүүл мэндийн төв, аймаг, дүүргийн сүрьеэгийн диспансер	Уушгины эмгэг сэжиглэн диспансерт илгээсэн болон сорьц зөөсөн хүний илэрсэн сүрьеэгийн тоо



							Тохиолдлын тоо
5	Хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагыг сүрьеэгийн илрүүлэг үзлэг хийхэд татан оролцуулах, үр дүнг тооцох	Жилийн турш	Хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудын нэгдсэн холбоо	Хувийн эмнэлгүүд ХӨСҮТ, СТСА Глобаль сан	Зөвөрлөсөн сорьцын тоо, сүрьеэгийн оношлогдсон тохиолдол		
6	Эрүүл мэндийн сайдын 2021 оны 30 дугаар тушаалаар баталсан "Сүрьеэгийн тусламж үйлчилгээ үзүүлэх журам, заавар" уушгины сүрьеэгийн оношилгооны алгоритмын хэрэгжилтийг үнэлэх	2-3 дугаар улирал	ХӨСҮТ, СТСА	Глобаль сан Аймаг, дүүргийн сүрьеэгийн диспансер	Үнэлгээний тайлан		
7	Цээжний гэрлийн шинжилгээнд өөрчлөлттэй иргэдийн сүрьеэ илрүүлэх шинжилгээний хамрагдалтыг үнэлэх	2-3 дугаар улирал	ХӨСҮТ, СТСА	Глобаль сан Аймаг, дүүргийн сүрьеэгийн диспансер Дүрс оношилгооны нийгэмлэг	Үнэлгээний тайлан		
8	Нян судлалын шинжилгээний хариу сөрөг иргэдийг цээжний гэрлийн шинжилгээнд хамруулах, илэрсэн өөрчлөлтийг нягтлах үйл ажиллагааг сүрьеэгийн диспансерт хэвшүүлэх	2-3 дугаар улирал	ХӨСҮТ, СТСА	Глобаль сан Аймаг, дүүргийн сүрьеэгийн диспансер	Эмнэлзүйн тохиолдлын тоо, хувь		
1.2	Идэвхтэй илрүүлэлт	Жилийн турш	ЭМГ, НЭ, БОЭТ, Өрхийн эрүүл мэндийн төв, аймаг, дүүргийн сүрьеэгийн диспансер	Аймаг, сумдын ЗДТГ, ТББ	Идэвхтэй илрүүлэлтээр илэрсэн сүрьеэгийн тохиолдлын тоо		



		2	Сонгогдсон сумын эрсдэлт бүлгийн хүн амыг халдварт, халдварт бус өвчний цогц үзлэгт хамруулах	2-3 дугаар улирал	МСЭМХ	Аймгийн ЗДТГ, ЭМГ, НЭ, БОЭТ, сумдын ЗДТГ, СЭМТ	Сүрьеэтэй илэрсэн тохиолдлын тоо, эмчилгээнд хамрагдсан хувь, эмчилгээний үр дүн -Илрүүлсэн артерийн гипертензи, чихрийн шижин, БЗДХ-ын тохиолдлын тоо /оношоор/
3	Сонгогдсон орон нутгийн уул уурхай, хувиараа ашигт малтмал олборлогч нарыг сүрьеэ илрүүлэх үзлэг шинжилгээнд хамруулах	2-3 дугаар улирал	МСЭМХ	Аймгийн ЗДТГ, ЭМГ, уул уурхайн компани, ХАМО нөхөрлөл	Үзлэгийн тайлан, Сүрьеэтэй илэрсэн тохиолдлын тоо, эмчилгээнд хамрагдсан хувь, эмчилгээний үр дүн		
4	Нийслэлийн Сонгинохайрхан, Баянзүрх, Баянгол, Сүхбаатар, Хан-Уул, Чингэлтэй дүүргийн гэр оронгүй иргэдийг сүрьеэгийн илрүүлэг үзлэгт хамруулах	Жилийн турш	МУЗН, Сонгинохайрхан, Баянзүрх, Баянгол, Сүхбаатар, Хан-Уул, Чингэлтэй дүүргийн Улаан	Дүүргийн цагдаагийн хэлтэс, ЭМТ, сүрьеэгийн диспансер, Энэрэл эмнэлэг	Идэвхтэй илрүүлэлтэд хамрагдсан гэр оронгүй иргэдийн тоо, илэрсэн тохиолдлын тоо, эмчилгээнд хамрагдсан хүний тоо,		

				загалмайн хороо		эмчилгээний үр дүн
	5	Сүрьеэгийн өвчлөл бүртгэгдсэн ЕБС-ийн сурагч, багш ажилчдыг сүрьеэгийн илрүүлэг үзлэгт хамруулах	Жилийн турш	ЭСИТ	ХӨСҮТ, Глобаль сан, Дүүргийн сүрьеэгийн диспансери	Үзлэгийн тайлан, илэрсэн тохиолдлын тоо
	6	Аж ахуйн нэгж, албан байгууллагатай хамтарсан сүрьеэгийн илрүүлэг үзлэгт цахим асуумжийг нэвтрүүлэх, ашиглах	Жилийн турш	МСТН	Глобаль сан, Сүрьеэгийн идэвхтэй	Илрүүлэлтэд хамрагдсан иргэдийн тоо
	7	Нийслэлийн амьжиргааны баталгаажих түвшнээс доогуур орлоготой (1-3 дугаар ангилал) иргэдийг сүрьеэгийн идэвхтэй илрүүлэлтэд хамруулах явуулын баг ажиллуулах	Жилийн турш	МСТН МӨАУМХ	Глобаль сан, Өрхийн эрүүл мэндийн төв, нийслэлийн ЭМГ, дүүргийн сүрьеэгийн диспансер	Үзлэгийн тайлан, Илрүүлсэн тохиолдлын тоо
	8	Сайн дурын идэвхтэнээр дамжуулан эрсдэлт бүлгийн иргэдээс сүрьеэ илрүүлэх асуумж авах, асуумжид суурилан тохиолдлыг сэжиглэх, диспансерт илгээх үйл ажиллагааг тогтмолжуулах	Жилийн турш	МСТН	Аймаг, дүүргийн сүрьеэгийн диспансер	СДИ-ний асуумжаар илрүүлж, диспансерт илгээсэн тохиолдлын тоо, илрүүлэлтийн хувь



			Сүрьеэгийн идэвхтэй илрүүлэг үзлэгийн мэдээллийн цахим санг бий болгох эрх зүйн орчныг бүрдүүлэх, мэдээлэлд дүн шинжилгээ хийх	Хагас жил тутам	МСТН	ХӨСҮТ, Глобаль сан	Улирал бүр
9		10	ШШГЕГ-ын харьяа нээлттэй, хаалттай хорих анги, Согтуурах мансуурах донтой өвчтөнг албадан эмчлэх, албадан хөдөлмөр хийлгэх газарт сүрьеэгийн идэвхтэй илрүүлэг үзлэгийг зохион байгуулах	Жилийн турш	Хорих 429 дүгээр анги	ХӨСҮТ-ийн СТСА, Глобаль сан, ШШГЕГ хорих ангиуд	Идэвхтэй илрүүлэлтэд хамрагдсан хоригдлын тоо, илрүүлэлтийн хувь, эмчилгээний үр дүн
11		1	Аймгийн төвд оршин суудаг сүрьеэд өртөх эрсдэлт бүлгийн иргэдийг сүрьеэгийн илрүүлэг үзлэгт хамруулах	Жилийн турш	МӨАУМХ	Өрхийн эрүүл мэндийн төв, аймаг, дүүргийн сүрьеэгийн диспансер, СТСА, ГС	Үзлэгт хамрагдсан иргэдийн тоо, илэрсэн сүрьеэтэй тохиолдлын тоо, хувь
1.3	Хавьтлын үзлэг шинжилгээ	1	Сүрьеэтэй өвчтөний хавьтлын хүрээг тодорхойлох, хавьтлын хяналтын үзлэг шинжилгээг тогтмолжуулах, далд халдварын эмчилгээний хувийг нэмэгдүүлэх зорилго бүхий аян, арга хэмжээг зохион байгуулах	Жилийн турш	МСЭМХ	Аймгийн ЭМГ, сүрьеэгийн диспансер, сумын нэгдсэн эмнэлэг, сумын эрүүл мэндийн төв	Хавьтлын хяналтын үзлэг тогтмол хамрагдсан хувь, далд халдварын эмчилгээнд хамрагдсан тохиолдлын тоо
2		2	Алслагдсан сумдын эрсдэлт бүлгийн хүн амд хүрч очиж сүрьеэгийн тандалтад хамруулах, сэжигтэй тохиолдлоос цэрний сорьц цуглуулах, сумаас аймаг руу зөөвөрлөх	Хүн амын дунд халдварын тархалт гарсан үед	МСЭМХ	Аймгийн ЭМГ, НЭ, БОЭТ-ийн сүрьеэгийн диспансер, СЭМТ	Хүрч очиж тандалтад хамруулсан эрсдэлт бүлгийн хүн амын сорьц цуглуулсан

1.4	Эмнэлэг хэвтэн эмчлүүлж байгаа КОВИД-19 халдварын батлагдсан тохиолдолд сүрьеэгийн илрүүлэг үзлэг хийх	1	Хэвтэн эмчлүүлж байгаа КОВИД-19 халдвар батлагдсан өвчтөнд сүрьеэгийн эмнэлзүйн тандалт хийх (2 долоо хоногоос удаан хугацаанд ханиалгаж байгаа, 2 долоо хоногоос удаан хугацаанд халуурч байгаа, биеийн жин огцом алдах, шөнө хөлрөх өгүүлэмжээр)	Жилийн турш	ХӨСҮТ, Аймаг нийслэлийн НЭ, БОЭТ, бусад эмнэлэг	Аймгийн ЭМГ, НЭ, БОЭТ-ийн сүрьеэгийн диспансер, Хувийн хэвшлийн ЭМБ	Сүрьеэ илрүүлэх асуумжид хамрагдсан Ковид-19-тай өвчтөний тоо, сүрьеэгийн шинжилгээнд хамрагдсан өвчтөний тоо, илэрсэн сүрьеэтэй өвчтөний тоо, хувь
3	Солонгосын үндэсний нийгэмлэгтэй хамтран "Сүрьеэгийн хавьтлын хяналтыг сайжруулах нь" төслийг хэрэгжүүлэх	2-4 дүгээр улирал	ХӨСҮТ-СТСА СҮСН, Койка	НЭМГ, дүүргийн ЭМТ, сүрьеэгийн диспансер	Сүрьеэтэй өвчтөний хавьтлын үзлэг шинжилгээний хамралтын хувь, далд халдварын эмчилгээнд хамрагдсан иргэдийн тоо	Сүрьеэгийн үзлэг хүн тоо, сорьц цуглуулсан хувь	

Хоёр. Сүрьеэгийн оношилгоо, шинжилгээ: сорьц цуглуулах, хадгалах, тээвэрлэх, хариу илгээх



2.1	Цэрний сорьц цуглуулах (оношилгоозмч илгээний хяналт)	1	Сумдын ЭМТ-ийн дунд аймгийн НЭ-ийн сүрьеэгийн диспансерт оношилгооны зорилгоор сорьц зөөвөрлөх үйл ажиллагааг сайжруулах болзолт уралдаан зохион байгуулах	Жилийн турш	МСЭМХ	Аймгийн ЭМГ, НЭ, БОЭТ-ийн сүрьеэгийн диспансер, СЭМТ	Оношилгооны зорилгоор зөөвөрлөсөн сорьцын тоо, эерэг илүүлэлтийн хувь, эмчилгээнд хамрагдсан хувь, эмчилгээний үр дүн
2	ХӨСҮТ-ийн сүрьеэгийн үндэсний лавлах лаборатори (СҮЛЛ)-т эмэнд тэсвэртэй сүрьеэгийн эмчилгээний хяналт, эмэнд мэдрэг чанар тодорхойлох шинжилгээ (ЭМЧТШ), өсгөвөрлөх шинжилгээнд сорьц илгээх	Жилийн турш	МСЭМХ	Аймгийн ЭМГ, НЭ, БОЭТ-ийн сүрьеэгийн диспансер	Эмчилгээний хяналтын зорилгоор илгээсэн тохиолдлын тоо, 1, 2 дугаар эгнээний ЭМЧТШ-д илгээсэн тохиолдлын тоо, өсгөвөрлөх шинжилгээнд илгээсэн тохиолдлын тоо, эмчилгээнд хамрагдсан хувь, эмчилгээний үр дүн		

		3	Сүрьеэтэй өвчтөний шинжилгээний хяналтын хугацаанд нь зөөвөрлөх үйл ажиллагаанд хяналт шинжилгээ хийх	Жилийн турш	МСЭМХ	Аймгийн ЭМГ, НЭ, БОЭТ-ийн сүрьеэгийн диспансер, СЭМТ	Хяналт шинжилгээний тайлан, Эмчилгээний хяналтын зорилгоор зөөсөн сорьцын тоо
2.2	Сорьц хадгалах, тээвэрлэх	1	Сүрьеэгийн оншилгоо, эмчилгээний хяналтын сорьцыг хадгалах, тээвэрлэхэд Эрүүл мэндийн сайд, Зам тээвэр хөгжлийн сайдын хамтарсан 2020 оны 413/165 дугаар тушаалыг хэрэгжүүлж байгаа эсэхэд дэмжлэгт хяналт хийх	Жилийн турш	Аймгийн ЭМГ, НЭ, БОЭТ-ийн сүрьеэгийн диспансер, СЭМТ	МСЭМХ МӨАУМХ	Зөөвөрлөсөн сорьцын тоо, илрүүлэлтийн хувь
2.3	Шинжилгээний хариуг мэдээлэх	1	Үйлчлүүлэгч, эрүүл мэндийн байгууллагад сүрьеэгийн шинжилгээний хариуг цахимаар хүргүүлэх	Жилийн турш	Аймгийн НЭ, БОЭТ, дүүргийн ЭМТ-ийн сүрьеэгийн диспансер, СЭМТ	МСЭМХ МӨАУМХ	Нийт мэдээлсэн шинжилгээний хариу
			Хорих ангид илэрсэн сүрьеэгийн болзошгүй тохиолдлоос сорьц цуглуулах, зөөвөрлөх	Тухай бүр	Хорих 429 дүгээр анги	ХӨСҮТ-ийн СТСА, Хорих анги	Сорьц өгсөн тохиолдлын тоо
		5	Сүрьеэгийн идэвхитэй илрүүлэг үзлэгээр илэрсэн сүрьеэгийн болзошгүй тохиолдлын сорьцыг зөөвөрлөх	Жилийн турш	МСТН	Аймгийн ЭМГ, НЭ, БОЭТ-ийн сүрьеэгийн диспансер, СЭМТ	Оношилгооны зорилгоор зөөвөрлөсөн сорьцын тоо, эерэг илүүлэлтийн хувь, эмчилгээнд хамрагдсан хувь, эмчилгээний үр дүн



<p><b>Гурав. Сүрьеэгийн эмчилгээний хяналт: хөл хорио, хязгаарлалтын дэглэм тогтоосон үед зайнаас хяналт тавих, тарилгатай эмчилгээний тасралтгүй байдлыг хангах</b></p>							
3.1	Өрх, сумын эрүүл мэндийн төвд хийх сүрьеэгийн эмчилгээ, эмчилгээний хяналт	1	“Сүрьеэгийн сорьц тээвэрлэлт”, “Сүрьеэгийн үргэлжлэх шатны эмчилгээ”, “Хавьтлын хяналт” туршлага солилцох уулзалт зохион байгуулах	3 дугаар улирал	МСЭМХ	Глобаль сан, аймгийн ЭМГ, сумын нэгдсэн эмнэлэг	Уулзалтын тайлан, оролцогсдын тоо
		2	Сүрьеэтэй өвчтөний эмчилгээг ӨЭМТ дээр, гэрээр, цахимаар тус тус хянаж уулгах, хамралтыг нэмэгдүүлж, хяналтыг сайжруулж, эмчилгээний үр дүнг дээшлүүлэх	Жилийн турш	МӨАУМХ	Нийслэлийн ЭМГ, ЭМТ - сүрьеэгийн диспансер, Глобаль сан	Эмчлэгдсэн хүний тоо, эдгэрсэн хувь
		3	Хороодын хамтарсан багийн гишүүдийг сүрьеэтэй өвчтөний эмчилгээний тасалдлыг арилгах чиглүүлэх сургалтад хамруулах, үйл ажиллагааг хэрэгжүүлэх	Жилийн турш	МӨАУМХ	НЭМГ, ХӨСҮТ-СТСА, ЗДТГ, дүүргийн сүрьеэгийн диспансер	Эмчилгээний тасалдал өмнөх оныхоос буурсан тоо
		4	ӨЭМТ-ийн зохицуулагчдыг сүрьеэгийн эмчилгээ, хяналтын талаар сургах	Жилийн турш	МӨАУМХ	НЭМГ, ХӨСҮТ-СТСА, дүүргийн сүрьеэгийн диспансер	Хамрагдсан зохицуулагчдын тоо
		5	Сүрьеэтэй өвчтөнийг хянах, зөвлөгөө өгөхөд Му doctor гар утасны аппликейшнийг нэвтрүүлэх	Жилийн турш	МӨАУМХ	Өрхийн эрүүл мэндийн төв, аймаг, дүүргийн сүрьеэгийн диспансер	Му doctor гар утасны аппликейшний татан авалтын тоо, өгсөн мэдээллийн тоо

3.2	Сүрьеэгийн диспансерт хийх эмчилгээ, эмчилгээний хяналт	1	Халдварын сэргийлэлт хяналтын дэглэмийг чанд мөрдөж, төлөвлөгөөт үйл ажиллагааны бэлтгэлийг хангаж, хэвийн явуулах	Жилийн турш	Хорих 429 дүгээр анги	Глобаль сан, Хорих 429,	Үйл ажиллагааны тайлан
3.3	Эрүүл мэндийн сайн дурын идэвхтэнээр дамжуулан хийх эмчилгээ, эмчилгээний хяналт	1	Эмчилгээний хяналт алдагдсан гэр оронгүй иргэнийг эрэн хайх үйл ажиллагаа зохион байгуулах, эмчилгээнд хамруулах	Хүн амын дунд халдварын тархалт гарсан үед	МУЗН	Энэрэл эмнэлэг Дүүргийн цагдаагийн хэлтэс	Хяналт алдагдсан өвчтөний тоо, эмчилгээнд хамрагдсан өвчтөний тоо, эмчилгээний үр дүн
		2	Сүрьеэгийн эмчилгээ хийлгэж байгаа амжиргааны баталгаажих түвшнээс доогуур орлоготой, ганц бие өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд хүнс, ариун цэврийн багцын тусламж үзүүлэх	1-2 дугаар улирал	МУЗН	Дүүргийн халамжийн хэлтэс, ЭМТ, сүрьеэгийн диспансер	Тусламжинд хамрагдсан өвчтөний тоо, эмчилгээний үр дүн,
		3	Сүрьеэгээр өвчилсөн гэр оронгүй иргэдийн эмчилгээг Энэрэл эмнэлэг, ТББ-ын шууд хяналтад бүрэн шилжүүлэх	Хүн амын дунд халдварын тархалт гарсан үед	МУЗН	ХӨСҮТ, Энэрэл эмнэлэг, Дөлгөөн минж, Өлзийт асар ТББ	Энэрэл эмнэлэгт эмчлүүлсэн өвчтөний тоо ТББ-ын хяналтанд эмчлэгдсэн өвчтөний тоо, эмчилгээний үр дүн
		4	Сүрьеэгийн эмийг шууд хяналттай, гэрээр уулгах үйлчилгээг хэвийн үргэлжлүүлэх	Жилийн турш	МСТН	Аймаг, нийслэлийн ЭМГ, сүрьеэгийн диспансер	Гэрээр эмчилгээнд хамрагдсан өвчтөний тоо, эмчилгээний үр дүн



		5	Сүрьеэгийн чиглэлээр ажилладаг сайн дурын идэвхтэний үйл ажиллагаанд дэмжлэгт хяналт хийх	Жилийн турш	МСТН, Аймаг, дүүргийн сүрьеэгийн зохицуулагчид	Аймаг, дүүргийн сүрьеэгийн диспансер	Дэмжлэгт хяналтын тоо, хамрагдсан СДИ, үйлчлүүлэгчдийн тоо
		6	Аймаг, дүүрэгт ажиллаж байгаа зохицуулагчдын тайланд үнэлгээ дүгнэлт хийж, тухай бүр мэргэжил арга зүйгээр хангах	Жилийн турш	МСТН	ЭМЯ, ХӨСҮТ, Глобаль сан	Сарын тайлан, эмчилгээнд хамрагдсан хувь, эмчилгээний үр дүн
3.4	Стационарт хийх эмчилгээ, эмчилгээний хяналт	1	Сүрьеэтэй өвчтөнд нийгэм сэтгэлзүйн зөвлөгөө өгөх	Жилийн турш	ХӨСҮТ, СТСА	ХӨСҮТ-ийн Сүрьеэгийн клиник, Глобаль сан	Зөвлөгөө авсан өвчтөний тоо, эмчилгээний үр дүн
3.5	Явуулын тусламж үйлчилгээ	1	Олон эмэнд тэсвэртэй сүрьеэтэй өвчтөнд эмнэлгийн тусламж үйлчилгээг хүргэх	Жилийн турш	ЭСИТ	Глобаль сан, ХӨСҮТ, дүүргийн сүрьеэгийн диспансер	Хүрч үйлчилсэн ОЭТС-тэй өвчтөний тоо, эмчилгээний үр дүн
3.6	Далд халдварын эмчилгээ	1	Далд халдварын эмчилгээний асуудал шийдвэрлэх эмч нарын зөвлөгөөнийг зохион байгуулах, шийдвэрийн хэрэгжилтэд дэмжлэгт хяналт хийх	Жилийн турш	Аймгийн нэгдсэн эмнэлэг, БОЭТ, Сүрьеэгийн диспансер	ХӨСҮТ, СТСА	Зөвлөгөөний шийдвэрийн тоо, эмчилгээнд хамрагдсан хүний тоо
		2	Сүрьеэгийн далд халдварын эмчилгээний хамралтад тогтмол хяналт хийх, хавьтлын тайланг нэгтгэх	Жилийн турш	ХӨСҮТ, СТСА	Аймгийн ЭМГ, Аймгийн нэгдсэн эмнэлэг, сүрьеэгийн диспансер	Сүрьеэгийн далд халдварын эмчилгээнд хамрагдсан хүний тоо
<b>Дөрөв. Нэмэлт үйл ажиллагаа: Эмч эмнэлгийн мэргэжилтэн, сайн дурын идэвхтэний хүний нөөц, ханган нийлүүлэлтийн менежмент, сургалт, хяналт үнэлгээ, эрсдэлийн үеийн мэдээлэл харилцаа холбоо, төр хувийн хэвшлийн түншлэл</b>							



4.1	Олон эмэнд тэсвэртэй сүрьеэ /ОЭТС/-ийн үндэсний зөвлөгөөн	1	Олон эмэнд тэсвэртэй сүрьеэгийн асуудлаарх үндэсний зөвлөгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулах	Жилийн турш	ХӨСҮТ, СТСА	Аймаг, дүүргийн сүрьеэгийн диспансер	Зөвлөгөөний тоо, хэлэлцсэн өвчтөний тоо
4.2	Цахим хяналт	1	Сүрьеэгийн эмчилгээний шууд хяналтад дижитал технологийн хэрэглээг үе шаттай нэвтрүүлэх	Жилийн турш	ХӨСҮТ, СТСА	Аймаг, дүүргийн сүрьеэгийн диспансер	Цахим хяналтад хамрагдсан өвчтөний тоо
4.3	Лабораторийн чанарын хяналт	1	Хрет MTB/RIF шинжилгээнд чанарын гадаад үнэлгээ хийх (Smart Quality's Xpert MTB/RIF EQO Program)	5, 11 дүгээр сар	ХӨСҮТ, СТСА	Аймаг, дүүргийн сүрьеэгийн лаборатори, Глобаль сан	Хамрагдсан нэгжийн тоо
		2	Түрхэцийн шинжилгээний гадаад чанарын хяналт хийх	Жилийн турш	ХӨСҮТ, СТСА	Аймаг, дүүргийн сүрьеэгийн лаборатори, Глобаль сан	Хамрагдсан нэгжийн тоо
		3	Сүрьеэгийн эмийг лабораторийн чанарын хяналтад хамруулах	2 дугаар улирал	ХӨСҮТ, СТСА	Аймаг, дүүргийн сүрьеэгийн лаборатори, диспансер Глобаль сан	Чанарын хяналтад хамрагдсан эмийн тоо
4.4	Ханган нийлүүлэлт	1	Глобаль сан, Засгийн газрын санхүүжилтээр нийлүүлэх сүрьеэгийн лабораторийн урвалж, оношлуурын захиалга хийх, хүргүүлэх	Жилийн турш	ХӨСҮТ, СТСА	Аймаг, дүүргийн сүрьеэгийн лаборатори, Глобаль сан	Нөөцийн хэмжээ
4.5	Эрсдэлийн үеийн харилцаа холбоо	1	Эрүүл мэндийн мэдээ мэдээлэл, зөвлөмжийг Глобаль сангийн ДОХ, сүрьеэгийн төслийн салбар хүлээн авагч байгууллагын цахим хуудас, олон нийтийн сүлжээ, хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан иргэдэд хүргэх	Жилийн турш	Салбар хүлээн авагчид МСЭМХ, МУЗН,	Эрүүл мэндийн байгууллагууд	Мэдээлэл, сурталчилгаан ыдавтамж, МСС-ны материалын нэр төрөл, тоо,



			МСТН, ЭСИТ	Хандалт, хуваалцсан тоо
2	Хорих 429 дүгээр анги, төвлөрсөн хорих ангийн өвчтөн, хоригдол, алба хаагчдад коронавируст /КОВИД-19/ халдвар, сүрьеэ өвчний талаар мэдээлэл өгөх	7 хоног бүр	Хорих 429 дүгээр анги	ХӨСҮТ-ийн СТСА, Глобаль сан
3	Сайн дурын идэвхтэнээр дамжуулан өвчтөн, гэр бүлд мэдээлэл өгөх, зурагт хуудас тараах	Жилийн турш	МСТН	Аймаг, дүүргийн сүрьеэгийн диспансер
4	ЕБС-ийн багш нарын дунд "Сүрьеэ өвчний талаар хэн сайн хичээл заах вэ" видео бичлэгийн уралдааныг зохион байгуулах	1 дүгээр улирал	МСТН	Аймаг, нийслэлийн ЭМГ
5	"Сүрьеэгүй Монголын төлөө нэгдэцгээе" цуврал подкаст, интерактив сургалтын материалыг насны бүлэг, эрсдэлт бүлгийн онцлогт тохируулан боловсруулах, олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгсэлээр үе шаттайгаар хүн амд хүргэх	Жилийн турш	МСТН, ЭСИТ	Аймаг, дүүргийн сүрьеэгийн зохицуулагчид
1	Сүрьеэгийн тусламж үйлчилгээг сайжруулах чиглэлээр орон нутгийн шийдвэр гаргагчдын зөвлөгөөнийг зохион байгуулах	2-3 дугаар улирал	ХӨСҮТ, СТСА	Аймаг, Зөвлөгөөнд оролцсон хүний тоо
2	Сүрьеэгийн лабораторийн эмч, мэргэжилтнүүдийн үндэсний зөвлөгөөн зохион байгуулах	3 дугаар улирал	ХӨСҮТ, СТСА	Аймаг, нийслэлийн ЭМГ, Глобаль сан
4.9	Үндэсний зөвлөгөөн, мэргэжлийн сургалт, уулзалт			Зөвлөгөөнд хамрагдсан хүний тоо



3	Сүрьеэгийн эмч, эмзүйч, сувилагч нарыг эмэнд тэсвэртэй сүрьеэгийн эмчилгээний богиносгосон горим, эмнэлзүйн менежментийн чиглэлээр сургах	2 дугаар улирал	ХӨСҮТ, СТСА	Аймаг, нийслэлийн ЭМГ, Глобаль сан	Сургалтад хамрагдсан хүний тоо
4	Сүрьеэгийн цахим бүртгэлийн ТУБИС шинэчлэгдсэн программын сургалт зохион байгуулах	3, 4 дүгээр улирал	ХӨСҮТ, СТСА	Аймаг, дүүргийн сүрьеэгийн диспансер, Глобаль сан	Сургалтад хамрагдсан эмч, мэргэжилтний тоо
5	Дундговь аймгийн Адаацаг сумын Засаг дарга, ЭМТ-тэй хамтран "Сүрьеэгүй сум" үзүүлэх сургалт зохион байгуулах	2 дугаар улирал	МСЭМХ	Глобаль сан, Дундговь аймгийн Адаацаг сумын ИТХ, Засаг дарга, ЭМТ	Үзүүлэх сургалтанд оролцогчдын тоо
6	Сүрьеэгээр өвчилсөн хүмүүжигч нараас үе тэнгийн сургагч бэлтгэх	2 дугаар улирал	Хорих 429 дүгээр анги	ХӨСҮТ, СТСА, Глобаль сан	Үе тэнгийн сургагчийн тоо
7	Халдварт өвчин, сүрьеэгийн оношилгоо, ялган оношилгоо, эмчилгээний чиглэлээр хүүхдийн мэргэжлийн эмч нарыг сургах	2 дугаар улирал	ЭСИТ	ХӨСҮТ, ЭХЭМҮТ	Сургасан хүүхдийн эмч нарын тоо
8	Аймаг, нийслэлийн 225 хамтарсан багийн гишүүдийг чадавхжуулах, сургах	3, 4 дүгээр улирал	МӨАУМХ	ХӨСҮТ, СТСА, Глобаль сан	Сургасан багийн тоо, сургалтын тайлан
9	Аймаг, нийслэлийн хамтарсан багийн туршлага солилцох Улсын зөвлөгөөн зохион байгуулах	3, 4 дүгээр улирал	МӨАУМХ	ХӨСҮТ, СТСА, Глобаль сан	Зөвлөгөөний тайлан
10	Хамтарсан багийн дунд болзолт уралдаан зарлах, дүгнэх, тэргүүний багийн үйл ажиллагааг хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчлах	2, 4 дүгээр улирал	МӨАУМХ	Аймаг, дүүргийн ЗДТГ, Глобаль сан	Тайлан



4.10	Хамтын ажиллагаа	1	Сүрьеэгийн оношилгоо эмчилгээг сайжруулах чиглэлээр эрүүл мэндийн байгууллага, мэргэжлийн нийгэмлэг, холбоодтой хамтран ажиллах гэрээ байгуулах	2 дугаар улирал	ХӨСҮТ, СТСА	Герантологийн үндэсний төв, УНТЭ, Чихрийн шижингийн холбоо, СЭМҮТ ЭСИТ	Хамтарсан байгууллагын тоо
		2	Аймаг дүүрэгт ажиллах дэмжлэгт хяналтын хуваарь гаргах, төлөвлөх, гүйцэтгэлийг үнэлэх	Улирал тутам	ХӨСҮТ, СТСА	Аймаг, дүүргийн сүрьеэгийн диспансер, Энэрэл эмнэлэг, СЭМҮТ, ШШГЕГ	Дэмжлэгт хяналтын тайлан
		3	Глобаль сангийн ДОХ, сүрьеэгийн төслийн сүрьеэгийн салбар хүлээн авагч байгууллагуудын мэдээлэл солилцооны платформыг хөгжүүлэх	Жилийн турш	МСТН	ХӨСҮТ, СТСА, ШШГЕГ, МУЗН, МСТН, МӨАУМХ, МСЭМХ, ЭСИТ	Үйл ажиллагааны тайлан, бүртгэл, мэдээ тайлагналт
						Глобаль сан	